




**1-р даалгавар**

Зураг дээрх амьтдын хөлийг тоолоод хэдэн амьтан байгааг олоорой. Нийт амьтны тоог дөрвөлжин дотор цэгээр тэмдэглээрэй.




**2-р даалгавар**

Зүүн гар талд байгаа нугалсан цаасыг дэлгэвэл ямар дүрс үүсэх вэ? Баруун гар талд байгаа дүрсүүдээс сонгон дугуйлна уу?



**3-р даалгавар**

Бяцхан дэгдээхий найзтайгаа тоглохоор үүрнээсээ гарлаа. Тэрээр газар сайн мэдэхгүй учир замын хажуугийн суман тэмдэглэгээг даган явсаар зорьсон газраа хүрэв. Дэгдээхий хаана очсон бэ? Очсон газрыг таван хошуу дүрсээр тэмдэглээрэй.



#### 4-р даалгавар

Орой унтахын өмнө юу хийх хэрэгтэй вэ? Доорх зургуудаас тохирохыг дугуйлна уу.





- Шүдээ угаах
- Орондоо гар утсаар тоглох
- Хувцсаа эвхэх
- Орондоо юм идэж, уух
- Тоглоомоо хураах



#### 5-р даалгавар

Болд хөдөө явж байлаа. Гэтэл замд нь чулуу тээглэв. Чулууг сөхөхөд дороос нь зөндөө амьтан гарч ирэв. Ямар амьтад гарч ирсэн бэ?



Нэгдүгээр даалгавар /Бөгцөг нясалж тоглох/

**Зорилго:** Багаар ажиллах чадвар, хамтын зорилгыг биелүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж чаддаг эсэх, бусдад санаа тавьж буй эсэх, баг доторхи тогтсон дүрмийг баримталж чадаж буй эсэх зэрэг нийгэмшихүйн чадамжийг үнэлэхэд оршино.

**Багшийн үйл ажиллагаа/40 минут/:** Нэг багт нийт 12 хүүхэд байна, хүүхэд бүр нуруундаа томоор хэвлэсэн дугаар наасан байна. Ангид орж ирэхэд үүдэнд гутлыг тайлуулна. Ангид орж ирсний дараа багш хүүхдүүдийг хоёр багт хуваан тойргоор суулгаж бөгцөг няслуулна. Чингэхдээ дараах тоглоомын дүрмийг чанга тод дуугаар уншиж сонсоно. Бөгцөг няслах явцад багш хүүхэд бүрийг сайтар ажиглаж, нийгэмшихүйн чадамжийг нь үнэлнэ.

**Тоглоомын дүрэм:** Тоглогч хүүхдүүд шагайг ээлжлэн орхиж, ижил ижлээр нь/ ямааг ямаатай, хонийг хоньтой, тэмээг тэмээтэй, морийг морьтой/ нясална.

- Нар зөв тойрох журмаар дарааллын дагуу няслах;
- Шагайг оноод, оносон шагайг нясалсан гараар авахгүй;
- Нясалсан гараар зангахгүй;
- Нясалсан шагайнаас өөр шагайнд хүрч хөндөхгүй;
- Огт оноогүй, өөр шагайг оносон бол аль ч шагайг авахгүйгээр дараагийн хүүхдэд няслах эрх шилжинэ;
- Дөрвөн бэрх буюу нэгэн зэрэг морь, тэмээ, ямаа, хонь бүгд гарсан тохиолдолд, шүүрнэ.
- Бүдүүлэг үг хэллэг хэрэглэж, нэгнийхээ өмнүүр дайрахгүй

**Үнэлгээний аргачлал:** Хүүхэд бүр ангид орж ирэхэд 20 оноотой байх ба дараах ажиглалтын хуудсан дахь хориглосон үйлдлийг хийсэн тохиолдолд тухайн оноог хасч тооцно. Онцгой тохиолдолд бонус нэмэлт оноог олгож болно.

	№	Шалгуур үзүүлэлт
Хасах онооны шалгуур үзүүлэлт	1	Гутлаа тайлж эмх цэгцтэй тавиагүй
	2	Багшийн тайлбарыг анхаараагүй
	3	Найз нөхдөө үл хүндэлсэн
	4	Бусдад хандан бүдүүлэг үг хэрэглэсэн
	5	Хүчээр асуудлыг шийдсэн
	6	Хүлээцгүй байсан
	7	Сэтгэл хөдлөлөө хянаж чадаагүй
	8	Тоглоомын үндсэн дүрмийг зөрчсөн
		0-2 удаа
		3-5
	5-аас олон удаа	
Хасах онооны шалгуур үзүүлэлт	9	Шагайгаа хураахад санаатайгаар оролцоогүй
	10	Бусдыг мэдэрч зохицоогүй, дураараа загнасан
Буонус оноо	1	Асуудлыг шийдвэрлэх бодит санаачлага гаргасан эсхүл хүмүүжлийн онцгой зэрэг хандлага гаргасан



Хоёрдугаар даалгавар: Уяа зангилаа тайлах

*Зорилго:* Хүүхдийн тэсвэр тэвчээр, ур ухаан, гарын хурууны эвсэл хөдөлгөөнийг шалгах

*Аргачлал:* Багш хүүхдүүдийг тойргоор суулгаж, анхаарлыг төвлөрүүлнэ. Даалгаврыг тайлбарлах өгнө. Зангилаа уяаг тараана. Минут харж, нэгэн зэрэг эхлүүлж зэрэг зогсооно. Даалгаврыг 2 минутын хугацаанд хийж гүйцэтгэх ба зангилааг гүйцэт тайлах албагүй. Багш хүүхдийг байранд нь суулгаж өөрөө тойрон явж, хүүхэд бүрийн **дутуу орхисон зангилааны тоог** үнэлгээний хуудсанд тэмдэглэнэ

Гуравдугаар даалгавар: Ангиа багаар цэвэрлэх

*Зорилго:* Хүүхдийн багаар асуудал шийдвэрлэх чадвар, ажлын эв дүй, хөдөлмөрч, шаргуу чанарыг үнэлэхэд оршино.

*Багшийн үйл ажиллагаа:* Багш багийн дунд 6 ширхэг чийгтэй шинэ алчуур тавьж, багаараа хэрэглэсэн анги, танхимаа цэвэрлэхийг уриална. Багш дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үйлийг ажиглаж оноог онооно. Тэмдэглэлийн хуудсанд 4 шалгуур үзүүлэлт бүрээс тухайн хүүхдэд тохирохыг чагт тэмдэгээр тэмдэглэнэ. Тарахад нь гарыг санитараар ариутгуулна.

*Үнэлгээний аргачлал:*

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт
1	Багийн ажилд оролцсон эсэх	Оролцсон бол
		Хойш суусан бол
2	Оролцоо	Чин сэтгэлээсээ цэвэрлэж байгаа бол
		Хуумгай хандаж байгаа бол
3	Хамтын ажиллагаа	Бусдад тусалж, хамтарч байгаа бол
		Мөрөөрөө ажиллаж байгаа бол
		Бусдад төвөг болж байгаа бол
4	Ажлын эв дүй	Эв дүйтэй
		Эв дүйгүй